2012 оны 10 сарын 22
(2-р хэвлэл)

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
# И-СОНИН

**Мэдээний тойм:**

- Харилцагчдын данс нээх баримт бичгийг брокер, дилерийн компаниас нэгтгэж, харилцагчийн өмнөөс банкинд хүргүүлж байна.
- Зах зээлийн мэдээ
- Бүртгэлтэй компанийн мэдээ
- "Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ба удирдах ажилтны хариуцлага" сэдэвт семинар зохион байгуулагдлаа.

## Харилцагчдын данс нээх баримт бичгийг брокер, дилерийн компаниас нэгтгэж, харилцагчийн өмнөөс банкинд хүргүүлж байна.

2012 оны 10 дугаар сарын 19-ны байдлаар шинэ систем, дүрэм журмын дагуу тавигдаж буй шаардлагыг хангасан арилжаанд оролцох эрхтэй гишүүн компанийн тоо 48-д хүрсэн бөгөөд эдгээр компаниуд нь зах зээлийн 95 хувийг эзэлдэг байна.

Түүнчлэн, Төлбөрийн баталгааны санд хөрөнгө байршуулсан компанийн тоо 56, МХБ-тэй хамтран ажиллах гэрээ шинэчлэн байгуулсан компанийн тоо 70, төлбөр тооцоо гүйцэтгэгч банктай гэрээ байгуулсан 56, барьцаа хөрөнгө байршуулсан компанийн тоо 50-д тус тус хүрээд байна.

2012 оны 8 дугаар сард Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв, Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкууд, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, гишүүн брокер дилерийн компаниудын төлөөлөлтэйгээр байгуулагдсан Монголын Хөрөнгийн зах зээлийн ажлын хэсгийн уулзалтуудаар харилцагчдын данс нээх явцыг хөнгөвчлөх үүднээс банкинд данс нээх баримт бичгийг брокер, дилерийн компаниуд нэгтгэж, харилцагчийн өмнөөс банкинд хүргүүлэх нэг цэгийн үйлчилгээг үзүүлэхээр хэлэлцэн шийдвэрлэсний дагуу банкинд нээгдэх дансны тоо нэмэгдсээр байна.

## Зах зээлийн мэдээ

### TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/




2012 оны 10 сарын 08-наас 2012 оны 10 сарын 19-ний хооронд нийт 10 удаагийн арилжаа явагдаж 56 компанийн 369.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий 1.4 сая ширхэг хувьцаа арилжсан байна. Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь 'Ремикон' ХК /83.4 сая.төг/, 'Монинжбар' ХК /46 сая.төг/, 'Гермес центр' ХК /42.8 сая.төг/ байсан байна.

**Монголын хөрөнгийн бирж**

**2 долоо хоногийн:**

| | |
|---|---|
| **Арилжигдсан ширхэг** | **1.4 сая** |
| **Арилжигдсан дүн** | **369.2 сая.төг** |
| **Арилжигдсан компанийн тоо** | **56** |
| **Хамгийн их өсөлттэй:** | **Дархан гурил тэжээл /DAR/ +32.1%** |
| | **Бэрх-Уул /BEU/ +29.9%** |
| | **Эрдэнэт суврага /SVR/ +15%** |
| **Хамгийн их бууралттай:** | **Газар сүлжмэл /SUL/ –15.6%** |
| | **Ханын материал /HMK/ –15%** |
| **Зах зээлийн үнэлгээ:** | **1,696.8 тэрбум.төг** |
| **TOP-20 индексийн өөрчлөлт:** | **16,550.12 / –2.76%** |
| **Индекс:** | **TOP-20** |
| **Вебсайт:** | **www.mse.mn** |

2012 оны 10 сарын 22
(2-р хэвлэл)

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
И-СОНИН

## Бүртгэлтэй компанийн мэдээ

**“Атар -Өргөө” ХК /MSE:ATR/-ийн хувьцааны нэрлэсэн үнэ өөрчлөгдлөө.**
СЗХ-ны 2012-09-12-ны өдрийн 282 тоот тогтоолын дагуу “Атар-Өргөө” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 174,136 ширхэг хувьцааны нэрлэсэн үнийг 18000 төгрөг болгож өөрчиллөө. Компанийн өөрийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой хувьцааны нэрлэсэн үнэ ийнхүү өөрчлөгдсөн байна.

**“Өвөрхангай ханын материал” ХК /MSE:HML/ нэрээ өөрчиллөө.**
МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2012-10-18-ны өдрийн А/133 тоот тушаалаар “Өвөрхангай ханын материал” ХК-ийн оноосон нэрийг “Глобал Монголиа Холдинг” ХК болгон МХБ-ийн бүртгэлд өөрчлөлт оруулаа. Компанийн үйл ажиллагаар сэргээх төлөвлөгөөний дагуу компани ийнхүү нэрээ өөрчилсөн байна.

**“Архуст шунхлай” ХК /MSE:SUN/-ийн дийлэнх хувьцаа эзэмшигчдээс үлдсэн 44%-ийг худалдан авах санал гаргав.**
СЗХ-ноос "Архуст шунхлай" ХК-ийн нийт гаргасан 75,874 ширхэг хувьцааны 56 хувь буюу 42,438 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох “Евроазиа Капитал Монголиа” ХХК, Г.Оюунболд нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 44 хувь буюу 33,436 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацаар 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоол гаргасан байна.

**“Шарын гол” ХК / MSE:SHG/-ийн удирдлага өөрчлөгдлөө.**
"Шарын гол" ХК нь компанийн хөгжил, өргөжилтийн ажлыг удирдан ажиллах шинэ гүйцэтгэх удирдлагын баг томилсон тухайгаа мэдэгдлээ. Шинэ удирдлагын багийн гишүүд нь олон улсын хүрээнд танигдсан уул уурхайн болон санхүүгийн мэргэжилтнүүдээс бүрдэж байгаа юм.

*Грам Чапман*, Гүйцэтгэх захирал, Нүүрс, уул уурхайн салбарт 30 гаруй жилийн арвин туршлагатай ба “Би Эйч Пи Биллитон” компанийн удирдлагын багийн гишүүн асан.

*Жеймс Флорес*, Санхүү эрхэлсэн захирал, “Норвест” ба “Роял Коул Корпораци”-ийн удирдлагын багийн гишүүн асан.

*Жеймс Гоулди*, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Австрали болон Индонезид томоохон нүүрсний уурхайн үйл ажиллагааг хариуцаж байсан.

ТУЗ-ийн даргаар Б.Батмөнх хэвээр байхаар болсон байна.

**“Бэрх Уул” ХК / MSE:BEU/ нь Дэлгэрхааны жоншны ордод NI 43-101 стандартын дагуу нөөцийн тайлан хийлгэжээ.**
“Бэрх Уул” ХК нь Дэлгэрхааны жоншны ордод олон улсын зөвлөх компани болох “Микромайн” компаниар NI 43-101 стандартын дагуу нөөцийн тайлан хийлгэснээ зарлалаа. Нийт 33.7%-ийн хүдрийн дундаж агуулгатай 6.62 сая тонн бодит нөөц, 33%-ийн хүдрийн дундаж агуулгатай 3.02 сая тонн боломжит нөөц тогтоогдсон байна. Нийтдээ 9.64 сая тонн хүдрийн боломжит болон бодит нөөц тогтоогдсон нь 3.22 сая тонн жоншны эрдэс ($CaF_2$) юм. Жоншны одоогийн зах зээлийн үнээр тооцвол, Дэлгэрхааны ордын нийт үнэ цэнэ 1.06 тэрбум ам.доллар байх тооцоо гарсан байна.

## “Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ба удирдах ажилтны хариуцлага” сэдэвт семинар зохион байгуулагдлаа.

МХБ-ээс “Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ба удирдах ажилтны хариуцлага“ сэдэвт семинарыг 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдөр “Мандал женерал даатгал” компанитай хамтран амжилттай зохион байгууллаа.

Уг семинарт МХБ-д бүртгэлтэй ХК-иудын гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийн төлөөлөл оролцсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, зах зээлд нэр хүнд бүхий аудитын, хууль зүйн, даатгалын компаниуд болон Компанийн засаглалын хөгжлийн төв зэрэг байгууллагуудаас илтгэл тавьсан юм. 2011 онд шинэчлэгдсэн “Компанийн тухай” хуулиар ХК-тай холбоотой маш олон өөрчлөлтүүд орсноос жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг тайлагнах, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зэрэг олон шаардлага хуульчлагдсантай холбоотой хувьцаат компанийн ТУЗ ба удирдах ажилтны үүрэг хариуцлага нэмэгдсэн талаар оролцогчид хэлэлцүүлэг өрнүүлж, санал туршлага солилцох ач холбогдол бүхий арга хэмжээ болж өндөрлөлөө.